



МОНГОЛ УЛС
БАЯНХОНГОР АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2023 оны 03 сарын 31 өдөр

Дугаар А/167

Номгон

“Бага насны хүүхдийн цогц хөгжил” сургалт,
үйл ажиллагаа зохион байгуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.1.2, Төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2.3, аймгийн Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөрийн 2.3.3, аймгийн 2023 оны хөгжлийн төлөвлөгөөний бодлогын баримт бичгүүдийн хэрэгжилтийг хангах 6.1.3 дахь заалтын задаргааны 6 дахь заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.“Бага насны хүүхдийн цогц хөгжил” сургалт, үйл ажиллагааг 2023 оны 4,5 дугаар сард зохион байгуулсугай.

2.“Бага насны хүүхдийн цогц хөгжил” сургалт, үйл ажиллагааг зохион байгуулах удирдамжийг нэгдүгээр, төсвийг хоёрдугаар хавсралтаар тус тус баталсугай.

3.Сургалт, үйл ажиллагааг тогтоосон хугацаанд чанартай зохион байгуулж, үр дүнг тайлагнаж ажиллахыг Боловсрол, шинжлэх ухааны газар (Ж.Алтанцэцэг)-т үүрэг болгосугай.

4.Сургалт, үйл ажиллагааны зардал болох 7.300.000 (Долоон сая гурван зуун мянган төгрөг)-ийг аймгийн 2023 оны хөгжлийн төлөвлөгөөний “Бага насны хүүхдийн цогц хөгжил” стратеги хэрэгжүүлэх төлөвлөгөөний зардлаас санхүүжүүлэхийг Санхүү, төрийн сангийн хэлтэс (С.Байгалмаа)-т зөвшөөрсүгэй.

5.Энэхүү захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Засаг даргын орлогч (Б.Батсуурь), Нийгмийн бодлогын хэлтэс (Б.Наранбаяр) нарт даалгасугай.


ДАРГА



Д.МӨНХСАЙХАН

642310419

Аймгийн Засаг даргын 2023 оны 03 дугаар сарын 31 ний
өдрийн 107 дугаар захирамжийн 1 дүгээр хавсралт



БАЯНХОНГОР АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ТАМГЫН ГАЗАР

УДИРДАМЖ

2023 оны 03 дугаар сарын 31

Номгон

“Бага насны хүүхдийн цогц хөгжил” сургалт,
үйл ажиллагаа зохион байгуулах тухай

Төрөөс боловсролын талаар баримтлах бодлогод Сургуулийн Өмнөх Боловсролыг хүний хөгжлийн үндэс, өөрийн онцлог, чадвар, бүтээлч үйлээрээ хөгжих, насан туршийн боловсролын суурь үе хэмээн хөгжүүлнэ” гэж заасан. Хүүхдийн амьдралын эхний жилүүд нь тэдний хөгжил, төлөвшилд нэн чухал төдийгүй цаашдын амьдралын суурь болдог. Бага насны хүүхдийн цогц хөгжлийг хангах, хөгжлийг дэмжихэд эцэг эх, асран хамгаалагч, гэр бүлийн гишүүдийн үүрэг, оролцоо чухал учир тэдэнд хүүхдээ асран хамгаалах, хүмүүжүүлэх, хөгжүүлэх, төлөвшүүлэхэд мэргэжлийн байгууллага, мэргэжилтнүүдийн дэмжлэг туслалцаа шаардлагатай. Тиймээс бага насны хүүхэдтэй гэр бүл, эцэг эхэд зөвлөгөө өгөх, зөвлөн туслах үйлчилгээ үгүйлэгдэж байна.

Хөтөлбөр хэрэгжих үндэслэл: Аймгийн засаг даргын 2020 оны 04 дүгээр сарын 22-ны өдрийн А/284 дүгээр захирамжийн дагуу “Бага насны хүүхдийн цогц хөгжил, хамтын ажиллагааны стратеги төлөвлөгөөг (2020-2024 он) баталсан.

Иймд “Цэцэрлэгийн хүүхэд хамгааллын бодлогыг хэрэгжүүлэхэд дэмжлэг үзүүлэх” мэргэжлийн арга зүйгээр хангах, явцын хэрэгжилтэд хяналт тавих, цаашид цэцэрлэгүүдэд энэ талаар зөвлөмж зөвлөгөө өгөх шаардлага байна.

Сургалтын зорилго:

Цэцэрлэгийн хүүхэд хамгааллын бодлогыг хэрэгжүүлэхэд дэмжлэг үзүүлэх,
Бага насны хүүхдийн аюулгүй байдлыг хангахад хамтын ажиллагааны стратегийг баримтлах, арга зүйн дэмжлэгээр хангах, сургалт, үйл ажиллагааг зохион байгуулж туршлага судлах

Оролцогчид: Цэцэрлэгийн эрхлэгч, арга зүйч, багш нар

Хугацаа: 2023 оны 04 дүгээр сарын 25-ны өдрөөс 05 дугаар сарын 03-ны өдрүүдэд үе шаттай зохион байгуулах

2.

Сургалт, үйл ажиллагааны агуулга, чиглэл:

1.Цэцэрлэгийн эрхлэгч, арга зүйч нарыг чадваржуулах “Бага насны хүүхдийн цогц хөгжил”-ийн сургагч багшаар бэлтгэн туршлага судлах ажил, арга хэмжээг зохион байгуулах

2.Сургуулийн Өмнөх Боловсролын багш нарт “СЭТГЭЛ ЗҮЙЧ-2” зөвлөгөө өгөх анхан шатны сургалт, үйл ажиллагааг зохион байгуулж цэцэрлэг түшиглэсэн СЭТГЭЛ ЗҮЙН ЗӨВЛӨГӨӨ ӨГӨХ ТАНХИМ байгуулах

3.Багш, удирдах ажилтны САЙН ТУРШЛАГА, сургалтын арга зүй, технологийг түгээн дэлгэрүүлэх ажил, арга хэмжээг зохион байгуулж технологийн санд бүртгүүлэх ажлыг хийх

4.“Багшийн хөгжил – арга зүйн шинэчлэл” төсөлт ажил сургалтын модуль боловсруулан мэргэжлийн хөгжлийн бүлгийг байгуулан ажиллах.

Сэдэв	Агуулга	Хариуцан эзэн
2023.05.01- 03-ны өдрүүд		
“Бага насны хүүхдийн цогц хөгжил”-ийн сургагч багшаар бэлтгэн туршлага судлах ажил, арга хэмжээг зохион байгуулах	1. Танилцуулга Сургалтын хэрэгцээ, зорилго, зохион байгуулалт, хичээл удирдах багш, танилцуулга	Сургуулийн өмнөх боловсролын мэргэжилтэн Н. Ариунболор
	2. Бага насны хүүхдийн хөгжлийн онцлог -Бага насны хүүхдэд зонхилон тохиолдох өвчлөл, амны хөндийн эрүүл ахуйн байдлыг сайжруулах -Бага насны хүүхдийн хоол тэжээл, өсөлт хөгжлийг дэмжих, зохистой хооллох зөв соёлыг төлөвшүүлэхэд дэмжлэг болох -Хүүхдийн эрх, хамгааллын эрх зүйн орчныг сайжруулах, урьдчилан сэргийлэх	А. Нармандах
	Нийслэлийн 262-р цэцэрлэгийн үйл ажиллагаатай танилцах Нийслэлийн 5-р цэцэрлэгийн хүүхэд хамгааллын багийн ажилтай танилцаж туршлага судлах,	Сургуулийн өмнөх боловсролын мэргэжилтэн Н. Ариунболор
2023 оны 04 дүгээр сарын 25		
Цэцэрлэг түшиглэсэн СЭТГЭЛ ЗҮЙН ЗӨВЛӨГӨӨ ӨГӨХ ТАНХИМ байгуулах	“СЭТГЭЛ ЗҮЙЧ-2” зөвлөгөө өгөх анхан шатны сургалт зохион байгуулж багш, туслах багш нарт Хүүхэд хамгааллын багт арга зүй өгөх зөвлөн туслах, “Цэцэрлэгийн орчин дахь хүүхэд хамгаалал” арга хэмжээг зохион байгуулах 16-р цэцэрлэгийг Сэтгэл зүйн зөвлөгөө танхим байгуулах ажлыг эхлүүлэх	Мэргэжилтэн Н. Ариунболор, Хүүхдийн Төлөө Үндэсний зөвлөлийн гишүүн Д. Ундраа
2023 оны 04 дүгээр сарын 26		

<p>Багш, удирдах ажилтны САЙН ТУРШЛАГАА хуваалцах ажил, арга хэмжээ зохион байгуулах</p>	<p>Цэцэрлэгийн менежмент, ур чадвар, харилцаа хандлага, туршлагаараа манлайлан ажиллаж буй цэцэрлэгийн удирдлага нарын арга зүй сайн туршлагаас суралцаж, бусдад түгээн дэлгэрүүлэх</p>	<p>Боловсрол, шинжлэх ухааны газрын дарга, албаны дарга нар, Сургуулийн өмнөх боловсролын мэргэжилтэн Н. Ариунболор</p>
<p>“Багшийн хөгжил – арга зүйн шинэчлэл” мэргэжлийн хөгжлийн бүлэг байгуулах</p>	<p>Байгууллагын гүйцэтгэлийн үнэлгээний VI систем ашиглан суурь гарааны түвшинд анализ хийн асуудлыг тодорхойлж төлөвлөлт, менежмент хийсэн үйл ажиллагаатай танилцах, сайжруулахад дэмжлэг үзүүлэх</p>	<p>Сургуулийн өмнөх боловсролын мэргэжилтэн Н. Ариунболор</p>

Аймгийн Засаг даргын 2003 он 12 дугаар сарын 31 ний
өдрийн 1157 дугаар захирамжийн 2 дугаар хавсралт



**“БАГА НАСНЫ ХҮҮХДИЙН ЦОГЦ ХӨГЖИЛ” СУРГАЛТ,
ҮЙЛ АЖИЛЛАГАА ЗОХИОН БАЙГУУЛАХ ТӨСӨВ**

№	Үйл ажиллагаа	Тоо, ширхэг	Нэг бүрийн үнэ	Бүгд үнэ
1	Бичгийн цаас	2 Боодол	22000	44000
2	Багшийн ажлын хөлс	1 өдөр 400.000	400000	400.000
3	Сэтгэл зүйн зөвлөгөө өгөх танхим байгуулахад хэрэгцээтэй материал гарын авлага, сургалтын хэрэглэгдэхүүн бэлдэх зардал	Фото цаас- 5 ш	20000	100.000
		Үлгэрийн багц- 10 ш	20000	200.000
		Ном, гарын авлага- 20 ш	25000	500.000
		Гарын авлага- 10ш	25000	250.000
		Тоглоом /багцаар/ - 10	45000	450.000
		Ус буцалгагч- 1	256000	256.000
		Принтер хор- 2	70000	140.000
		Эсгий бал- 25	3000	75000
		Фосфор цаас- боодол	35000	35000
4	Багш, удирдах ажилтны САЙН ТУРШЛАГА шалгаруулах шагналд /Удирдах ажилтан- 4 хүн Багш – 4 хүн/	Өргөмжлөл- 8 ш	15000	120.000
		Хөнгөн цай 90 хүн 2 өдөр= 180 хүн	7000	1.260.000
		Мөнгөн шагнал- 8 хүний	I- 160000 II- 140000 III- 120000 IV- 80000	500.000
5	Замын зардал бензин (ирж, очих)	30 хүн	60*49500	2.970.000
	Нийт төсөв: Долоон сая гурван зуун мянган төгрөг			7.300.000 төг

-----oOo-----